



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

АУДИТЫН КОД: САГ-2026/262/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.</p> <hr/> <p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 260512 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn Ахлах аудитор: С.Болортуяа Утас: 261628 Цахим хаяг: bolortuyas@audit.gov.mn “ЦЭБЭ Консалтинг аудит” ХХК-ийн захирал: Д.Энхбаатар Утас: 77114235 Цахим хаяг: audit@tsebeconsulting.mn</p>
--	--

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	16
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	17
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	18
4. Аудитын тайлан	22
4.1 Ерөнхий зүйл	22
4.2 Материаллаг байдал	22
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	26
5. Аудитын илрүүлэлт	26
5.1 Зөвлөмж	24
5.2 Төлбөрийн акт.....	26
5.3 Албан шаардлага.....	28
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	29

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/398
танай _____-ны № _____-т

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН
СЭРГЭЭН ЗАСАХ ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ М.АМАРЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,063,542.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан 1,520,935.1 мянган төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээг хийгээгүй;
- Албаны хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй, 50,188.2 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүн худалдан авч нөөцөлсөн;
- Албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан орлон гүйцэтгэх үүрэгтэй ажилтнуудад хавсран ажилласны нийт 38,824.1 мянган төгрөгийн нэмэгдлийг хавтгайруулан олгосон;
- Худалдан авсан 41,904.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь УСНББОУС болон Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Засгийн газрын 2018 оны 382 тогтоол, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, Төрийн аудитын тухай хуулийн 23 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн

тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "нийцсэн ба зохистой байх", "ангилал", "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 546,137.2 мянган төгрөгийн нэмэлт орлого бүрдүүлснээс 258,759.0 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 287,378.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв нь тайлант онд дээд шатны байгууллагаас нийт 80,791.1 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн байна.

Бусад асуудал

Тус төвийн 2025 оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан 7 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 91.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



[Handwritten signature] ЦНАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Балансын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		2,592,884,598.99	2,888,372,792.18
33	АВЛАГА	5	521,316,934.70	874,023,905.30
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		165,190,200.00	-
33300	Татаас санхүүжилтийн авлага		356,000,000.00	874,023,905.30
33500	Бусад авлага		126,734.70	-
33510	Байгууллагаас авах авлага		126,734.70	-
35	БАРАА МАТЕРИАЛ	6	2,071,567,664.29	2,014,348,886.88
35100	Түүхий эд материал		262,589,131.38	234,657,208.47
35110	Тусгай зориулалттай материал		55,386,477.00	34,123,471.80
35130	Эм боох материал		207,202,654.38	200,533,736.67
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		31,812,551.27	32,549,323.50
354	Хангамжийн материал		1,777,165,981.64	1,747,142,354.91
35410	Бичиг хэргийн материал		7,008,769.00	5,740,912.00
35420	Аж ахуйн материал		17,781,798.67	13,749,155.01
35440	Түлш, шатах тослох материал		979,750.48	1,004,610.48
35460	Хүнсний материал		123,085,810.34	43,498,969.76
35470	Бусад хангамжийн материал		1,628,309,853.15	1,683,148,707.66
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		4,807,353,500.81	3,862,757,193.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	4,807,353,500.81	3,862,757,193.80
39200	Биет хөрөнгө		4,513,057,750.81	3,568,461,443.80
39203	Авто тээврийн хэрэгсэл		205,950,000.00	394,054,212.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(102,858,125.19)	(222,653,981.19)
39205	Машин тоног төхөөрөмж		7,928,685,010.57	7,863,039,702.42
39206	Хуримтлагдсан элэгдэл		(4,122,680,044.69)	(4,961,098,136.71)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		1,135,105,947.41	1,142,173,947.41
39208	Хуримтлагдсан элэгдэл		(531,145,037.29)	(647,054,300.13)
39300	Биет бус хөрөнгө		294,295,750.00	294,295,750.00
39301	Программ хангамж		687,621,076.36	687,621,076.36
39302	Хуримтлагдсан элэгдэл		(687,621,076.36)	(687,621,076.36)
39303	Бусад биет бус хөрөнгө		294,295,750.00	294,295,750.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		<u>7,400,238,099.80</u>	<u>6,751,129,985.98</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		-	106,846,461.46
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		-	106,846,461.46

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41300	Өглөг	9	-	106,846,461.46
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		-	11,068,446.46
41360	Бусад өглөг		-	95,778,015.00
41361	Байгууллагад төлөх өглөг		-	95,778,015.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		7,400,238,099.80	6,644,283,524.52
51	Засгийн газрын хувь оролцоо		7,400,238,099.80	6,644,283,524.52
51100	Засгийн газрын оруулсан капитал		294,295,750.00	294,295,750.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		294,295,750.00	294,295,750.00
51200	Хуримтлагдсан үр дүн		7,105,942,349.80	6,349,987,774.52
51210	Өмнөх үеийн үр дүн		8,320,681,150.89	7,105,942,349.80
51220	Тайлант үеийн үр дүн		(1,214,738,801.09)	(755,954,575.28)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		7,400,238,099.80	6,751,129,985.98

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2	10,476,402,981.00	7,834,871,116.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		412,497,225.00	7,834,871,116.10
120	Нийтлэг татварын бус орлого		412,497,225.00	292,597,352.97
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		60,198,008.00	55,045,985.55
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		60,198,008.00	55,045,985.55
120005	Түрээсийн орлого		-	4,000,000.00
120009	Бусад орлого		-	95,298,836.22
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Үндсэн хөрөнгө		261,462,100.00	114,290,527.20
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал		90,837,117.00	23,962,004.00
122	Тусламжийн орлого		-	7,542,273,763.13
1221	Хандив тусламж / дотоод/		-	7,542,273,763.13
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого		-	5,172,539,532.77
122111	Урсгал санхүүжилтийн орлого		-	5,172,539,532.77

**Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		-	184,137,230.36
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		-	184,137,230.36
12215	Төсөв хоорондын хандив, тусламж		-	2,185,597,000.00
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого \ЭМДС-УТ\		-	2,185,597,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		10,063,905,756.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		7,603,477,098.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		7,603,477,098.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,583,380,346.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас бий болсон нэмэлт орлого		178,122,778.00	-
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		1,405,257,568.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс		877,048,312.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас		877,048,312.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	11,691,244,380.09	8,477,963,164.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ		11,691,244,380.09	8,477,963,164.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		8,834,215,882.65	8,102,081,798.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		5,605,153,626.59	5,358,747,742.20
210101	Үндсэн цалин		2,895,253,979.81	3,127,797,625.22
210102	Нэмэгдэл		1,875,354,898.78	1,221,313,274.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт		435,390,000.00	633,168,919.00
210104	Урамшуулал		399,154,748.00	376,467,923.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		689,448,464.18	602,913,746.48
210201	Тэтгэврийн даатгал		483,157,433.18	419,048,814.02
210202	Тэтгэмжийн даатгал		56,442,229.48	46,471,912.13
210203	ҮОМШӨ-ний даатгал		30,621,676.27	26,511,021.02
210204	Ажилгүйдлийн даатгал		21,679,845.02	19,177,051.02
210205	Эрүүл мэндийн даатгал		97,547,280.23	91,704,948.29

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		243,287,760.27	289,087,642.80
210301	Гэрэл, цахилгаан		134,365,319.69	193,851,569.59
210302	Түлш, халаалт		76,515,509.51	65,382,546.43
210303	Цэвэр, бохир ус		32,406,931.07	29,853,526.78
2104	Хангамж, бараа материалын зардал		121,554,708.82	71,967,538.66
210401	Бичиг хэрэг		18,963,052.99	17,488,857.00
210402	Тээвэр, шатахуун		15,698,072.00	10,345,392.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		7,132,477.25	6,407,555.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		20,190,142.33	21,163,163.66
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		59,570,964.25	16,562,571.00
2105	Норматив зардал		565,798,313.25	458,058,896.12
210501	Эм		239,251,346.79	173,434,230.68
210502	Хоол, хүнс		249,158,063.96	266,890,782.58
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		77,388,902.50	17,733,882.86
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		119,489,426.00	166,311,578.00
210601	Багаж техник хэрэгсэл		11,966,150.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		3,898,950.00	775,500.00
210604	Урсгал засвар		103,624,326.00	165,536,078.00
2107	Томилолт, зочны зардал		5,860,000.00	33,180,000.00
210702	Дотоод албан томилолт		5,860,000.00	33,180,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		68,879,244.96	9,091,043.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		41,443,311.96	6,143,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		5,000,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар		200,000.00	148,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		99,000.00	-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс		2,453,000.00	290,000.00
210807	Газрын төлбөр		2,509,843.00	2,509,843.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал		17,174,090.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,414,744,338.58	1,112,723,610.86

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал		32,286,202.50	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		110,335,656.00	38,600,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		1,272,122,480.08	1,074,123,210.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,857,028,497.44	375,881,366.06
2132	Бусад урсгал шилжүүлэг		47,165,898.00	115,639,859.00
213203	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		-	5,301,759.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох 1 удаагийн мөнгөн тэтгэмж		44,593,898.00	53,977,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,572,000.00	56,360,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		2,809,862,599.44	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		2,652,277,740.98	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		157,584,858.46	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		-	260,241,507.06
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		-	260,241,507.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		(1,214,841,399.09)	(643,092,048.08)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		102,598.00	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз		102,598.00	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)		-	112,862,527.20
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз		-	112,862,527.20
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI)=(IV-V)		102,598.00	(112,862,527.20)
7	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		(1,214,738,801.09)	(755,954,575.28)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН		10,983,608,564.00	8,146,902,656.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		63,198,008.00	8,146,902,656.98
120	Нийтлэг татварын бус орлого		63,198,008.00	55,770,988.55
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		63,198,008.00	55,770,988.55
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		5,115,000.00	28,636,705.30
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		58,083,008.00	27,134,283.25
122	Тусламжийн орлого		-	8,091,131,668.43
1221	Хандив тусламж		-	8,091,131,668.43
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого		-	5,199,676,238.07
122111	Урсгал санхүүжилтийн орлого		-	5,199,676,238.07
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		-	544,568,230.36
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		-	544,568,230.36
12215	Төсөв хоорондын хандив, тусламж		-	2,346,887,200.00
122151	Улсын эмнэлгүүдэд ЭМДС-с олгох шилжүүлгийн орлого		-	2,346,887,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		10,920,410,556.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		7,603,477,098.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		7,603,477,098.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,912,380,346.00	-

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		507,122,778.00	-
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		1,405,257,568.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		1,404,553,112.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		1,404,553,112.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		10,851,075,364.01	8,101,174,856.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ		10,851,075,364.01	8,101,174,856.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		7,638,046,866.57	6,831,003,639.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		5,604,837,118.70	5,370,701,364.40
210101	Үндсэн цалин		2,355,937,701.39	2,942,258,735.16
210102	Нэмэгдэл		2,416,628,235.31	1,381,405,860.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт		435,614,112.00	612,883,501.00
210104	Урамшуулал		396,657,070.00	434,153,268.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		689,575,198.88	595,878,440.55
210201	Тэтгэврийн даатгал		483,284,167.88	419,049,814.02
210202	Тэтгэмжийн даатгал		56,442,229.48	46,471,913.53
210203	ҮОМШӨ-ний даатгал		30,621,676.27	26,511,021.02
210204	Ажилгүйдлийн даатгал		21,679,845.02	19,177,051.02
210205	Эрүүл мэндийн даатгал		97,547,280.23	84,669,640.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		243,287,760.27	288,885,841.37
210301	Гэрэл, цахилгаан		134,365,319.69	193,851,569.59
210302	Түлш, халаалт		76,515,509.51	65,340,100.00
210303	Цэвэр, бохир ус		32,406,931.07	29,694,171.78
2104	Хангамж, бараа материалын зардал		105,806,672.25	45,511,472.00
210401	Бичиг хэрэг		18,890,720.00	5,056,000.00
210402	Тээвэр, шатахуун		10,740,000.00	9,350,740.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		7,132,477.25	6,618,755.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		19,990,591.00	14,474,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		49,052,884.00	10,011,977.00

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Норматив зардал		631,015,711.00	319,604,180.00
210501	Эм, бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл		278,256,466.00	158,350,580.00
210502	Хоол, хүнс		278,353,215.00	161,253,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		74,406,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		143,757,590.01	129,915,298.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		14,173,850.01	41,472,755.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		10,982,751.00	264,000.00
210604	Урсгал засвар		118,600,989.00	88,178,543.00
2107	Томилолт, зочны зардал		5,860,000.00	31,390,000.00
210702	Дотоод албан томилолт		5,860,000.00	31,390,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		71,387,554.96	8,921,643.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		41,443,311.96	5,973,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		5,000,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар		200,000.00	148,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		99,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		2,453,000.00	290,000.00
210807	Газрын төлбөр		2,509,843.00	2,509,843.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		19,682,400.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		142,519,260.50	40,195,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		32,183,604.50	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		110,335,656.00	40,195,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,213,028,497.44	1,270,171,217.66
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		-	287,169,212.36
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг		-	287,169,212.36
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		-	287,169,212.36
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох		-	287,169,212.36

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	төвлөрүүлэх шилжүүлгийн зардал			
2132	Бусад урсгал шилжүүлэг		47,165,898.00	110,338,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох 1 удаагийн мөнгөн тэтгэмж		44,593,898.00	109,338,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,572,000.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		3,165,862,599.44	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		2,652,277,740.98	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		513,584,858.46	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		-	872,663,905.30
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		-	872,663,905.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		132,533,199.09	45,727,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН		132,533,199.99	45,727,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		132,533,199.99	45,727,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр		132,533,199.99	45,727,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		132,533,199.99	45,727,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		<u>(132,533,199.99)</u>	<u>(45,727,800.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	294,295,750.00	8,320,681,150.89	8,614,976,900.89
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	294,295,750.00	8,320,681,150.89	8,614,976,900.89
Тайлант үеийн үр дүн	-	(1,214,738,801.09)	(1,214,738,801.09)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	294,295,750.00	7,105,942,349.80	7,400,238,099.80
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	294,295,750.00	7,105,942,349.80	7,400,238,099.80
Тайлант үеийн үр дүн	-	(755,954,575.28)	(755,954,575.28)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	294,295,750.00	6,349,987,774.52	6,644,283,524.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	8,504,256,300.00	7,602,334,426.62	(901,921,873.38)	89.4
12	Татварын бус орлого	8,504,256,300.00	7,602,334,426.62	(901,921,873.38)	89.4
120	Нийтлэг татварын бус орлого	30,000,000.00	55,770,988.55	25,770,988.55	185.9
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	-	28,636,705.30	28,636,705.30	-
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	30,000,000.00	27,134,283.25	(2,865,716.75)	90.4
122	Тусламжийн орлого	8,474,256,300.00	7,546,563,438.07	(927,692,861.93)	89.1
12200	Хандив тусламж	1,500,000,000.00	2,346,887,200.00	846,887,200.00	156.5
122005	Төсвөөс санхүүжих	6,974,256,300.00	5,199,676,238.07	(1,774,580,061.93)	74.6
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,504,256,300.00	6,728,310,521.32	(1,775,945,778.68)	79.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,504,256,300.00	6,728,310,521.32	(1,775,945,778.68)	79.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,393,912,400.00	6,617,972,421.32	(1,775,939,978.68)	78.8

**Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,257,221,100.00	5,370,701,364.40	(886,519,735.60)	85.8
210101	Үндсэн цалин	2,983,503,600.00	2,942,258,735.16	(41,244,864.84)	98.6
210102	Нэмэгдэл	1,752,215,700.00	1,381,405,860.24	(370,809,839.76)	78.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,037,184,500.00	612,883,501.00	(424,300,999.00)	59.1
210104	Урамшуулал	484,317,300.00	434,153,268.00	(50,164,032.00)	89.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	781,903,000.00	595,878,440.55	(186,024,559.45)	76.2
210201	Тэтгэврийн даатгал	532,211,800.00	419,048,814.02	(113,162,985.98)	78.7
210202	Тэтгэмжийн даатгал	62,470,800.00	46,471,913.53	(15,998,886.47)	74.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	31,524,100.00	26,511,021.02	(5,013,078.98)	84.1
210204	Ажилгүйдлийн даатгал	31,011,400.00	19,177,051.02	(11,834,348.98)	61.8
210205	Эрүүл мэндийн даатгал	124,684,900.00	84,669,640.96	(40,015,259.04)	67.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	348,296,500.00	288,885,841.37	(59,410,658.63)	82.9
210301	Гэрэл, цахилгаан	210,912,300.00	193,851,569.59	(17,060,730.41)	91.9
210302	Түлш, халаалт	65,349,100.00	65,340,100.00	(9,000.00)	100.0
210303	Цэвэр, бохир ус	72,035,100.00	29,694,171.78	(42,340,928.22)	41.2
2104	Хангамж, бараа материалын зардал	76,481,000.00	41,640,232.00	(34,840,768.00)	54.4
210401	Бичиг хэрэг	6,271,900.00	5,056,000.00	(1,215,900.00)	80.6
210402	Тээвэр, шатахуун	5,479,500.00	5,479,500.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,908,000.00	6,618,755.00	(3,289,245.00)	66.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,192,700.00	14,474,000.00	(18,718,700.00)	43.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,628,900.00	10,011,977.00	(11,616,923.00)	46.3
2105	Норматив зардал	845,903,300.00	306,290,780.00	(539,612,520.00)	36.2
210501	Эм, бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл	380,525,100.00	158,350,580.00	(222,174,520.00)	41.6
210502	Хоол, хүнс	382,296,600.00	147,940,200.00	(234,356,400.00)	38.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	83,081,600.00	-	(83,081,600.00)	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,250,500.00	3,466,520.00	(18,783,980.00)	15.6
210601	Багаж техник хэрэглэл	19,048,000.00	264,000.00	(18,784,000.00)	1.4
210604	Урсгал засвар	3,202,500.00	3,202,520.00	20.00	100.0
2107	Томилолт зочны зардал	1,700,000.00	1,700,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	1,700,000.00	1,700,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн	56,699,400.00	5,951,643.00	(50,747,757.00)	10.5

**Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

	ажил, үйлчилгээний төлбөр, хураамж				
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	4,046,100.00	3,003,800.00	(1,042,300.00)	74.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,749,900.00	-	(5,749,900.00)	-
210803	Даатгалын үйлчилгээ	7,563,200.00	-	(7,563,200.00)	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	179,900.00	148,000.00	(31,900.00)	82.3
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	3,784,600.00	-	(3,784,600.00)	-
210806	Мэдээллийн технологийн зардал	1,344,300.00	290,000.00	(1,054,300.00)	21.6
210807	Нийтлэг үйлчилгээний төлбөр хураамж	2,509,900.00	2,509,843.00	(57.00)	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	31,521,500.00	-	(31,521,500.00)	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,457,600.00	3,457,600.00	-	100.0
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	3,457,600.00	3,457,600.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	110,343,900.00	110,338,100.00	(5,800.00)	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	110,343,900.00	110,338,100.00	(5,800.00)	100.0
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	109,343,900.00	109,338,100.00	(5,800.00)	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	874,023,905.30	874,023,905.30	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(874,023,905.30)	(874,023,905.30)	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	189	172	(17)	91.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	131	124	(7)	94.7
620003	Үйлчлэх ажилтан	57	47	(10)	82.4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	544,568,230.36
12	Татварын бус орлого	-	544,568,230.36
122	Тусламжийн орлого	-	544,568,230.36
1221	Хандив тусламж /дотоод/	-	544,568,230.36
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	544,568,230.36
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	544,568,230.36
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	257,399,018.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	257,399,018.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	257,399,018.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	3,871,240.0
210402	Тээвэр, шатахуун	-	3,871,240.0
2105	Норматив зардал	-	13,313,400.00
210502	Хоол, хүнс	-	13,313,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	170,816,578.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	63,180,555.00
210604	Урсгал засвар	-	107,636,023.00
2107	Томилолт, зочны зардал	-	29,690,000.00
210702	Дотоод албан томилолт	-	29,690,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	2,970,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,970,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	36,737,800.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	-	36,737,800.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	287,169,212.36
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(287,169,212.36)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлэх, тэдэнд тохирох туслах хэрэгсэл, хэрэглэгдэхүүнээр хангах, үйлдвэрлэх чиглэлээр өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлчилгээ эрхэлдэг төрийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газар бөгөөд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тус төв нь эрхэм зорилгоо "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэлхийн жишигт хүрсэн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээг тав тухтай орчинд үзүүлэхэд оршино" гэж тодорхойлсон байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нотолгоонд тулгуурласан эрүүл мэнд, боловсрол, нийгмийн сэргээн засах төрөлжсөн мэргэжлийн гурав дахь шатлалын тусламж үйлчилгээг улсын хэмжээнд үзүүлэх;
- Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай хүүхдэд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх;
- Хүүхдийн сэргээн засах чиглэлээр төгсөлтийн дараах сургалт эрхлэн явуулж, салбарын тэргүүлэх эмч, мэргэжилтэн бэлтгэх, эрдэм судлалын ажлыг дэмжих, өргөжүүлэх;
- Бусад байгууллагад мэргэжил, арга зүйн лавлагаа тусламж үзүүлэх;
- Хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон хөтөлбөрийг боловсруулан эцэг эх, гэр бүл, мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохирох туслах хэрэгсэл, хэрэглэгдэхүүнээр хангах, үйлдвэрлэх;
- Хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5-т Аж ахуйн нэгж, байгууллага нь "Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно."
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах

зүйлсийг хориглоно.” дараах заалтуудыг нэмсэн. Үүнд: Тус хуулийн 15.1.8 “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах”, 15.2.7 “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх.”

- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар тогтоол “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэх батлах тухай”
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгавар.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус төвийн даргын 2021 оны А/28 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн

талаар нарийн тусгаагүй, шинээр гарсан хууль тогтоомж, дүрэм, журмын өөрчлөлтийг тусгах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэжээ.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 649,108.1 мянган төгрөгөөр буюу 8.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	521,316.9	874,023.9	352,707.0
Бараа материал	2,071,567.7	2,014,348.9	(57,218.8)
Үндсэн хөрөнгө	4,807,353.5	3,862,757.2	(944,596.3)
Нийт хөрөнгө	7,400,238.1	6,751,130.0	(649,108.1)
Өр төлбөр	-	106,846.5	106,846.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	7,400,238.1	6,644,283.5	(755,954.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,400,238.1	6,751,130.0	(649,108.1)

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдэл 874,023.9 мянган төгрөг болж 352,707.0 мянган төгрөгөөр өссөн нь ЭМДЕГ-аас авах санхүүжилтийн авлага хугацаандаа орж ирээгүйгээс шалтгаалсан.
- Бараа материалын дансны үлдэгдэл 2,014,348.9 мянган төгрөг болж 57,218.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 425,942.2 мянган төгрөгийн эм, боох хэрэгсэл, хүнсний материал, аж ахуйн материал, хангамжийн материал худалдан авч, үйл ажиллагаанд 521,472.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,862,757.2 мянган төгрөг болж 57,218.8 мянган төгрөгөөр буурсан нь дээд шатны төсвийн захирагчаас 7 нэр төрлийн 31 ширхэг 80,791.1 мянган төгрөгийн үнэ бүхий сонсгол болон хараа шалгах төхөөрөмж, суурин компьютер, хөргөгч зэрэг хөрөнгийг нийлүүлж, 29 ширхэг тоног төхөөрөмжийг 48,735.8 мянган төгрөгөөр худалдан авсан, тайлант онд 1,074,123.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой.
- Богино хугацаат өр төлбөр 106,846.5 мянган төгрөг болсон нь бэлтгэн нийлүүлэгчдэд төлөх төлбөрийг цаг хугацаанд нь барагдуулаагүйтэй холбоотой.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,644,283.5 мянган төгрөг болсон нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан.

Программ хангамжийн бүртгэл, тайлагналтай холбоотой судалгаа:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв нь санхүүгийн үйл ажиллагаанд 3, урсгал үйл ажиллагаанд 11, нийт 687,621.1 мянган төгрөгийн, үлдэх өртөггүй 16 программ хангамжтай байна. Анх худалдан авснаас хойш программын хөгжүүлэлт хийгдээгүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 7,979,521.9 мянган төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангаас 1,500,000.0 мянган төгрөгөөр, үндсэн болон туслах үйл ажиллагаанаас 30,000.0 мянган төгрөгөөр, нийт 9,509,521.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс зардлыг 623,645.1 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс 7,355,876.8 мянган төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангаас 1,500,000.0 мянган төгрөгөөр, туслах үйл ажиллагаанаас 30,000.0 мянган төгрөгөөр, нийт 8,885,876.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор төсвийг нийт 381,620.5 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс 6,974,256.3 мянган төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангаас 1,500,000.0 мянган төгрөгөөр, туслах үйл ажиллагаанаас 30,000.0 мянган төгрөгөөр, нийт 8,504,256.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 6,974,256.3 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 1,500,000.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 30,000.0 мянган төгрөг орлого бүрдүүлэхээс гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,199,676.2 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 2,346,887.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 55,771.0 мянган төгрөг нийт 7,602,334.4 мянган төгрөг бүрдүүлж, 6,728,310.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 874,023.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,728,310.5 мянган төгрөг буюу 79.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллыг 886,519.7 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 186,024.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлыг 59,410.7 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 34,840.8 мянган төгрөг, нормативт зардлыг 539,612.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 50,747.8 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	8,393,912.4	6,614,968.6	(1,778,943.8)	77.8
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	110,343.9	110,338.1	(5.8)	99.9
81569 Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	4,046.1	3,003.8	(1,545.0)	74.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын 2025 оны А/168 дугаар тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн бүтэц орон тоог 189 байхаас 172 ажилтантай байхаар бууруулж баталсан. Тайлант хугацаанд батлагдсан орон тоогоор ажилласан байна.
- Төвийн даргын 2024 оны 09 дүгээр сарын А/57 тушаалаар ажилтанд 1 өдрийн хоолны хөнгөлөлт 10.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлт 10.0 мянган төгрөгөөр тооцож олгохоор баталсан байна. Унаа хоолны хөнгөлөлтийн зардлын гүйцэтгэл 612,883.5 мянган төгрөг буюу 59.1 хувьтай байгаа нь зардлын төсвийг 424,301.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвд гадаад томилолтын зардал гараагүй;
- Тайлант онд сургалт, семинар, хурал зөвлөгөөний зардал гаргаагүй;
- Хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай ажил, үйлчилгээний гэрээ байгуулаагүй;
- Төрд хохирол учруулсан зардал гаргаагүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 190,137.2 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулсан гэрээний дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас орсон орлогоос давсан 356,000.0 мянган төгрөг, нийт 546,137.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Үүнээс хангамж, бараа материалын зардалд 3,871.2 мянган төгрөг, нормативт зардал 13,313.4 мянган төгрөг, урсгал засварт 170,816.6 мянган төгрөг, дотоод томилолтын зардалд 29,690.0 мянган төгрөг,

бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 2,970.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 36,737.8 мянган төгрөг, нийт 257,399.0 мянган төгрөгийг зарцуулж, 287,169.2 мянган төгрөгийг санхүүжилтийн авлагаар тооцож, улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн даргын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/25, 05 дугаар сарын 16-ны өдрийн А/55 дугаар тушаалаар 2025 оны худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулж, 2025 оны худалдан авах батлагдсан 884,772.1 мянган төгрөгийн 7 багц төлөвлөгөөгөөр ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn цахим сайтад байршуулж, зохион байгуулж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой нягтлан бодох бүртгэл хөтлөлт, ажиллагсдын цалин хөлс, нэмэгдлийг журмын хүрээнд олгох, үндсэн хөрөнгийн бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахтай холбоотой асуудалд өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “ЦЭБЭ Консалтинг аудит” ХХК-ийн ахлах аудитор Г.Баянжаргал, аудитор Д.Мэндбаяр нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг, аудитын менежер Ж.Эрдэнэбилэг, захирал Д.Энхбаатар, Санхүүгийн аудитын газрын аудитор С.Болортуяа, аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “ЦЭБЭ Консалтинг аудит” ХХК-нд 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/26 дугаар албан бичгээр, хуулийн хугацаа 5 хоног хоцроож ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлын 10,983,608.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 109,836.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хэмнэх боломжтой зардлуудыг хэмнэх дараах арга хэмжээ авч ажилласан байна. Үүнд: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тайлант онд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллыг 886,519.7 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 186,024.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлыг 59,410.7 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 2 зөрчилд өмнөх оны аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, ажилдаа хариуцлагагүй хандсан ажилтанд хариуцлага тооцох 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 18 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан, өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэхийг хамруулан шалгалаа.

1. Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд ил тод 157 мэдээлэл байршуулахаас 151 мэдээллийг байршуулж, батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, зориулалт, арга хэмжээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 6 мэдээллийг хугацаа хоцроож, журмын хавсралт, маягтын дагуу мэдээллийг бүрэн гүйцэд, үнэн зөв оруулаагүй, өмнөх оны аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг биелүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.3.2-т “төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт”, 6.4.4-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитын хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, холбогдох албан ажилтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Илрүүлэлт:

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, төсвийн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн

54.5-д заасны дагуу иж бүрэн бэлтгэж хуульд заасан шалгуурыг хангаагүй, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаа 5 хоног хоцроож ирүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх.”, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх;”, 54 дүгээр зүйлийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна:” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаа хоцроож, иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Илрүүлэлт:

Ажилтанд нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн даргын тушаалыг 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн Б/151, Б/152 дугаартай, 2 өөр мөнгөн дүнтэйгээр гаргасан байна. Энэ нь Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоол "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 3.5.2-т "гэрээ хэлэлцээр, санамж бичгийг ажил үүргийн дагуу хариуцсан ажилтан оны эхнээс дугаарлан бүртгэл хөтөлж, мэдээллийн сан үүсгэсэн байна.", 2.2.4.1-т "баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, Монгол хэлний зөв бичих дүрэм, стандартад заасан шаардлагын дагуу зохион бүрдүүлж, түүний үнэн зөв, албан ёсны хүчинтэй байдлыг ханган боловсруулж, хянуулах, батлуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тушаал, шийдвэрийн төслийг хууль тогтоомжид нийцүүлж, хяналт тавьж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар төвийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хамруулж, санхүүгийн тайланд шинжилгээ хийж, цалингийн тооцоолол, мөнгөн хөрөнгө, бараа материалын дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвд танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар нийт 391,299.2 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илрүүлж, 352,401.8 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, залруулагдаагүй 38,824.1 мянган төгрөгийн 1 зөрчлийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэж, хэрэгжилтийг үнэлэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Өмнөх оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үлдэгдлийг 2025 оны эхний үлдэгдэлтэй тулган шалгахад цэвэр хөрөнгийн дүн 102.6 мянган төгрөгийн зөрүүтэй;
- Өмнөх оны аудитлагдсан санхүүгийн үр дүнгийн тайлангийн үлдэгдлийг 2025 оны эхний үлдэгдэлтэй тулган шалгахад үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл 352,299.2 мянган төгрөгийн зөрүүтэй байсныг тус тус залруулга хийлгэсэн.

4.5.2 Өмнөх оны аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон нийт 974,845.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 980.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 150,146.2 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 823,719.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 10 зөвлөмж өгсөн.

Аудитын шийдвэрийн хэрэгжилт дунджаар 67.6 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	980.0	1	980.0	100.0
Албан шаардлага	3	150,146.2	3	76,574.6	51.0
Зөвлөмж	10	823,719.1	6	428,333.9	52.0
Нийт дүн	14	974,845.3	10	505,888.5	67.6

- Өмнөх оны аудитаар элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох, холбогдох дээд байгууллагад хандан шийдвэрлэх, зөрчлийг таслан зогсоох албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд үлдэх өртөггүй хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн байх тул даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, захиргаа, удирдлагын газрын Санхүү албаны дарга нарт зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн болно.

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудад анхаарлаа хандуулж аудитын горим, сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой шинэчлэн батлагдсан заавар, журмуудын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг шинэчилсэн эсэх;
- Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу гэрээ байгуулсан өдрөөс эхлэн ажилтныг нийгмийн даатгалд албан журмаар даатгуулсан эсэх;
- Ажилтнуудад урамшуулал олгох даргын баталсан тушаал шийдвэрийн утга нь үндэслэсэн хууль, журмын заалттай нийцсэн эсэх;

- Бараа материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийг зохих дансанд шилжүүлэн бүртгэсэн эсэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 46,306.6 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Түрээсийн орлого 26,406.7 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны болон үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор нэр данс зөрүүтэй бүртгэсэн;
- Улсын төвлөрсөн төсвийн санхүүжилтийн 19,899.9 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн дансанд бүртгэсэн.

Эдгээр алдаанууд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", гэж заасантай тус тус нийцэхгүй УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулгын 1.27 болон санхүүгийн аудитын "Оршин байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 2,063,542.1 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 3,574.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх 3 төлбөрийн акт тогтоож, 2,043,047.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 10 албан шаардлага хүргүүлж, 16,920.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн нийт 2,063,542.1 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,953,706.0 мянган төгрөгөөр их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Илрүүлэлт:

Дотоод албан томилолтоор ажилласан 32 ажилтанд нийт 2,560.0 мянган төгрөгийн хоолны зардлыг давхардуулж олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүнин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын 2.2-т “Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ”, 2.2.3-т “Хоолны зардал” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтнуудад давхардуулж олгосон хоолны зардлыг буруутай ажилтнаар төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

2. Илрүүлэлт:

Төвийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн Б/260 дугаар тушаалаар томилогдсон ажилтанд ажилласан хоногийг буруу тооцоолсноос цалин, нэмэгдэл, хоолны хөнгөлөлтийн нийт 306.9 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилласан хоногийг буруу тооцоолж олгосныг буруутай ажилтнаар төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3. Илрүүлэлт:

Тайлант онд 3 ажилтанд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлс нийт 707.8 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг илүү тооцож олгосныг буруутай ажилтнаар төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

1. Илрүүлэлт:

Даргын А/32 дугаар тушаалаар ажилчдыг 3 багт хуваан тэмцээн уралдаан зохион байгуулж, оролцогчдод 1 сарын цалингийн 5-15 хувиар тооцож нийт 13,359.7 мянган төгрөгийн шагнал олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;”, 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг

зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй, төсвийн хэмнэлтийн бодлогыг баримталж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Илрүүлэлт:

Тус төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй компьютер, тоног төхөөрөмж, программ хангамж зэрэг нийт 67 нэр төрлийн 1,520,935.1 мянган төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй, өмнөх онд өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "...элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, ... эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитын зөвлөмжийг биелүүлээгүй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлээгүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Илрүүлэлт:

Төвийн даргын 2025 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн А/36, 5 дугаар сарын 15-ны өдрийн А/54, 5 дугаар сарын 23-ны өдрийн А/60 дугаар тушаалуудаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн Ерөнхий газар, Сэргээн засалт сургалт үйлдвэрлэлийн төвийн ажилтнуудыг Хөвсгөл, Дундговь, Говь-Алтай аймгуудад зохион байгуулагдсан сургалтад оролцуулахад түрээсийн автобус, шатахууны зардалд нийт 5,088.6 мянган төгрөгийг санхүүгийн дэмжих баримтгүйгээр зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.2.7-д

"сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, санхүүгийн анхан шатны баримтгүйгээр зардал гаргасан, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4. Илрүүлэлт:

Тус байгууллага нь тайлант онд төлбөрийг хугацаанд төлж барагдуулаагүйгээс 106,846.5 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 70 дугаар зүйлийн 70.5-т "Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах", гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийг хугацаанд нь барагдуулаагүй зөрчлийг арилгаж, нэмж өр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5. Илрүүлэлт:

Тус байгууллага нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлээгүй, 59 нэр төрлийн 263,901.2 мянган төгрөгийн өртөгтэй бараа ажил үйлчилгээг шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.", Засгийн газрын 2024 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

6. Илрүүлэлт:

Тус байгууллага нь 2025 оны 1-9 саруудад ажилтан албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод заасан орлон гүйцэтгэх үүрэгтэй нийт 16 ажилтанд ажил хавсран

гүйцэтгэсэн нэрийдлээр нийт 38,824.1 мянган төгрөгийн нэмэгдлийг хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин урамшуулал олгох журмын 2 дугаар зүйлийн 2.1-т "Төрийн албаны тухай хуулийн 42.1-т заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно.", Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6-д "Ажилтанд эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсний болон бусад нэмэгдэл хөлсний хэмжээг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг олгохдоо холбогдох хууль, журмыг баримтлаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

7. Илрүүлэлт:

Тайлант онд худалдан авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан 18 нэр төрлийн 41,904.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн, өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна. Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр гаргах тохиолдолд цахим гарын үсэг хэрэглэж баталгаажуулна.", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын аравдугаар бүлгийн 10.6-д "Хөрөнгө хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж, үндсэн хөрөнгийн тодорхойлолтод нийцсэн бөгөөд байгууллагын хэрэгцээнд ашиглах, бусдад түрээслүүлэх зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, нягтлан бодох бүртгэлийн хууль, журам, зааврыг мөрдөөгүй, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

8. Илрүүлэлт:

Тайлант онд үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй нийт 50,188.2 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүн, ахуйн материал нөөцөлж худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх," Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална." гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй, эм, эмийн хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүн, ахуйн материал нөөцөлж худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

9. Илрүүлэлт:

Тус байгууллага нь 2025 оны 6 дугаар сарын 4-ний өдөр "ГХГБ Ундрага" ХХК-тай байгуулсан ХБХСЗХТ/002/002 дугаартай худалдан авах гэрээний үнийн дүнгээс 2,000.0 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүний илүү орлого авч өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хүнсний бүтээгдэхүүний орлогыг бодит байдлаас илүү авч, өр төлбөр үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, дотоод хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

1 Илрүүлэлт:

Төвийн даргын А/92 дугаар тушаалаар Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврыг зөрчин 16,920.0 мянган төгрөгийн дотоод томилолтын зардал гаргасан байна.

Энэ нь Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 сарын 10-ны өдрийн "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" 05 дугаар албан даалгаврын 1.4-т "тэвчиж болох дараах арга хэмжээ, зардлын санхүүжилтийг 2025 он дуустал хугацаанд зогсоож, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг хэмнэлттэй, үр ашигтай байдлаар зохион байгуулах,"; 1.4.1-т "хурал, семинар, сургалтыг цахимаар зохион байгуулж, дотоод, гадаад томилолт, тээвэр шатахуун, зочин, төлөөлөгч хүлээн авах", 1.4.5-т "төрийн байгууллагын хэрэгжүүлдэг төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлын санхүүжилтийг дараагийн төсвийн жилд шилжүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Дээд шатны байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийг мөрдөн ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Түрээсийн орлого 26,406.7 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны болон үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор нэр данс зөрүүлж бүртгэсэн.	1	26,406.7	1	26,406.7			1	26,406.7				
Улсын төвлөрсөн төсвийн санхүүжилт 19,899.9 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн дансанд бүртгэсэн.	1	19,899.9	1	19,899.9			1	19,899.9				
Дүн	2	46,306.6	2	46,306.6			2	46,306.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Даргын А/32 дугаар тушаалаар ажилчдыг 3 багт хувааж тэмцээн уралдаан зохион байгуулж, оролцогчдод 1 сарын цалингийн 5-15 хувиар тооцон нийт 13,359.7 мянган төгрөгийн шагнал олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан байна.	1	13,359.7			1	13,359.7						
Тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй компьютер, тоног төхөөрөмж, программ хангамж	1	1,520,935.1			1	1,520,935.1						

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

зэрэг нийт 67 нэр төрлийн 1,520,935.1 мянган төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй, өмнөх онд өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй байна.												
Төвийн даргын 2025 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн А/36, 5 дугаар сарын 15-ны өдрийн А/54, 5 дугаар сарын 23-ны өдрийн А/60 дугаар тушаалуудаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн Ерөнхий газар, Сэргээн засалт сургалт үйлдвэрлэлийн төвийн ажилтнуудыг Хөвсгөл, Дундговь, Говь-Алтай аймгуудад зохион байгуулагдсан сургалтад оролцуулахад түрээсийн автобус, шатахууны зардалд нийт 5,088.6 мянган төгрөгийг санхүүгийн дэмжих баримтгүйгээр зарцуулсан.	1	5,088.6			1	5,088.6						
Тайлант онд албан томилолтоор ажилласан 32 ажилтанд 2,560.0 мянган төгрөгийн хоолны зардлыг давхардуулж олгосон.	1	2,560.0	1	2,560.0								
Тус байгууллага нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлээгүй, 59 нэр төрлийн 263,901.2 мянган төгрөгийн өртөгтэй бараа ажил үйлчилгээг шууд худалдан авалт хийсэн.	1	263,901.2			1	263,901.2						
Тус байгууллага нь тайлант онд төлбөрийг хугацаанд төлж барагдуулаагүйгээс 106,846.5	1	106,846.5			1	106,846.5						

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн												
Тайлант онд худалдан авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан 18 нэр төрлийн 41,904.0 мянган төгрөгийн хөрөнгийг материалын дансанд бүртгэсэн, өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	41,904.0			1	41,904.0						
- Дотоод томилолтоор ажиллаж байх хугацаанд нь 2 ажилтанд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлс нийт 404.4 мянган төгрөгийг илүү тооцож олгосон. - Тайлант оны 11 дүгээр сард ажилтанд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлс 303.4 мянган төгрөгийг илүү тооцож олгосон.	1	707.8	1	707.8								
Тус байгууллага нь 2025 оны 1-9 саруудад ажилтны ажлын байрны тодорхойлолтод заасан орлон гүйцэтгэх үүрэгтэй нийт 16 ажилтанд ажил хавсран гүйцэтгэсэн нэрийдлээр нийт 38,824.1 мянган төгрөгийн нэмэгдлийг хавтгайруулан олгосон	1	38,824.1			1	38,824.1						
Тайлант онд үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй нийт 50,188.2 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүн, ахуйн материал нөөцөлж худалдан авалт хийсэн	1	50,188.2			1	50,188.2						
Тус байгууллага нь 2025 оны 6 дугаар сарын 4-ний өдөр "ГХГБ Ундрага" ХХК-тай байгуулсан ХБХСЗХТ/002/002 дугаартай худалдан авах гэрээний үнийн дүнгээс 2,000.0 мянган төгрөгийн	1	2,000.0			1	2,000.0						

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

хүнсний бүтээгдэхүүн илүү орлого авч өр төлбөр үүсгэсэн.												
Даргын А/92 дугаар тушаалаар Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврыг зөрчин, 16,920.0 мянган төгрөгийн дотоод томилолтын зардал гаргасан.	1	16,920.0					1	16,920.0				
Тус байгууллагын даргын 2025 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн Б/260 дугаар тушаалаар томилогдсон ажилтанд ажилласан хоногийг буруу тооцоолсноос цалин, нэмэгдэл, хоолны хөнгөлөлтийн нийт 306.9 мянган төгрөгийг илүү тооцож олгосон.	1	306.9	1	306.9								
Дүн	13	2,063,542.1	3	3,574.7	9	2,043,047.4	1	16,920.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
1	Шилэн дансны цахим хуудсанд ил тод 157 мэдээлэл байршуулахаас 151 мэдээллийг байршуулж, батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, зориулалт, арга хэмжээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 884,820.7 мянган төгрөгийн 6 мэдээллийг хугацаа хоцроож, журмын хавсралт, маягтын дагуу мэдээллийг бүрэн гүйцэд, үнэн зөв оруулаагүй, өмнөх оны аудитаар хүргүүлсэн	1	-								1	-

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.									
	Дүн	1	-						1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
1	Төсвийн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, хуульд заасан шалгуурыг хангаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаа 5 хоног хоцроож ирүүлсэн.	1	-			1	-			
2	Ажилтанд 1 удаагийн мөнгөн тэтгэмж олгох Даргын тушаалыг Б/151, Б/152 дугаартай, 2 өөр мөнгөн дүнтэйгээр гаргасан.	1	-					1	-	
	Дүн	2	-			1	-	1	-	
	Нийт дүн	3	-			1	-	1	-	1



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 87/А0150169

Улаанбаатар хот

СДТ- 2026/202/МА-СТА Түгэз

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд албан томилолтоор ажилласан 32 ажилтанд нийт 2,560,000.00 /хоёр сая таван зуун жаран мянган/ төгрөгийн хоолны зардлыг давхардуулж олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 2.2-т "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ" 2.2.3-т "Хоолны зардал" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв нь ажилтнуудад давхардуулж олгосон хоолны зардал 2,560,000.00 /хоёр сая таван зуун жаран мянган/ төгрөгийг тооцооны нягтлан бодогч /Г.Даваахүү/-ээр нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Амаржаргал/, Захиргаа, удирдлагын газрын Санхүү албаны дарга /С.Майцэцэг/ нарт харууцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Д.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\kr\20260225 SAG-52.Docx

1526:60552



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 88/20150169

Улаанбаатар хот

СМ-2026/262/АА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Дотоод томилолтоор ажиллаж байх хугацаанд нь 2 ажилтанд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлс нийт 404,411.00 /дөрвөн зуун дөрвөн мянга дөрвөн зуун арван нэгэн/ төгрөгийг илүү тооцож олгосон.
2. Тайлант оны 11 дүгээр сард ажилтанд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлс 303,395.00 /гурван зуун гурван мянга гурван зуун ерэн таван/ төгрөгийг илүү тооцож олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-т "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн;" 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв нь ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг илүү тооцож олгосон 707,806.00 /долоон зуун долоон мянга найман зуун зургаан/ төгрөгийг тооцооны нягтлан бодогч /Г.Даваахүү/-ээр нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Амаржаргал/, Захиргаа, удирдлагын газрын Санхүү албаны дарга /С.Майцэцэг/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Д.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\kri\2026\0225 SAG-52.Docx

1526160554



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 89/А0150169

Улаанбаатар хот

СМ-2026/062/НЭ-СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын даргын 2025 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн Б/260 дугаар тушаалаар томилогдсон ажилтанд ажилласан хоногийг буруу тооцоолсноос цалин, нэмэгдэл, хоолны хөнгөлөлтийн нийт 306,937.00 /гурван зуун зургаан мянга есөн зуун гучин долоон/ төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв нь илүү тооцож олгосон 306,937.00 /гурван зуун зургаан мянга есөн зуун гучин долоон/ төгрөгийг тооцооны нягтлан бодогч /Г.Даваахүү/-ээр нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Амаржаргал/, Захиргаа, удирдлагын газрын Санхүү албаны дарга /С.Майцэцэг/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Д.ЭНХБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 461/А0150169

Улаанбаатар хот

САГ-2026/262/НА-СТА-ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд 157 мэдээлэл байршуулахаас 151 мэдээллийг байршуулж, батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, зориулалт, арга хэмжээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний нийт 884,820,700.00 /найман зуун наян дөрвөн сая найман зуун хорин мянга долоон зуун/ төгрөгийн 6 мэдээллийг хугацаа хоцроож, мэдээллийг иж бүрэн байршуулаагүй, өмнөх оны аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.3.2-т "төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт", 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн тооцооны нягтлан бодогч /Г.Даваахүү/, Захиргаа, удирдлагын газрын Санхүү албаны дарга /С.Майцэцэг/ нарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Амаржаргал/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Д.ЭНХБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 452/А0150169

Улаанбаатар хот

САГ-2026/262/НА -СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, төсвийн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу иж бүрэн бэлтгэж хуульд заасан шалгуурыг хангаагүй, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаа 5 хоног хоцроож ирүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх.", Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх;", 54 дүгээр зүйлийн 54.5-д "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна;" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх", "Топилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол;"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаа хоцроож, иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Амаржаргал/, Захиргаа, удирдлагын газрын Санхүү албаны дарга /С.Майцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Д.ЭНХБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 459/A0150169

Улаанбаатар хот

САГ-2026/262/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төвийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/32 дугаар тушаалаар ажилчдыг 3 багт хувааж тэмцээн уралдаан зохион байгуулж, оролцогчдод 1 сарын цалингийн 5-15 хувиар тооцож нийт 13,359,733.00 /арван гурван сая гурван зуун тавин есөн мянга долоон зуун гучин гурван/ төгрөгийн шагнал олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т, Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан", 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй, төсвийн хэмнэлтийн бодлогыг баримталж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Амаржаргал/, Захиргаа, удирдлагын газрын Санхүү албаны дарга /С.Майцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Д.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-78.Docx

1526180982



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 451/A0150169

Улаанбаатар хот

САГ-2026/262/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй компьютер, тоног төхөөрөмж, программ хангамж зэрэг нийт 67 нэр төрлийн 1,520,935,088.00 /нэг тэрбум таван зуун хорин сая есөн зуун гучин таван мянга наян найман/ төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "...элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, ... эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол,"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Амаржаргал/, Захиргаа, удирдлагын газрын Санхүү албаны дарга /С.Майцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 460/А0150169

Улаанбаатар хот

САГ-2026/262/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төвийн даргын 2025 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн А/36, 5 дугаар сарын 15-ны өдрийн А/54, 5 дугаар сарын 23-ны өдрийн А/60 дугаар тушаалуудаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн Ерөнхий газар, Сэргээн засалт сургалт үйлдвэрлэлийн төвийн ажилтнуудыг Хөвсгөл, Дундговь, Говь-Алтай аймгуудад зохион байгуулагдсан сургалтад оролцуулахад түрээсийн автобус, шатахууны зардалд нийт 5,088,640.00 /таван сая наян найман мянга зургаан зуун дөчин/ төгрөгийг санхүүгийн дэмжих баримтгүйгээр зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн анхан шатны баримтгүйгээр зардал гаргасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Амаржаргал/, Захиргаа, удирдлагын газрын Санхүү албаны дарга /С.Майцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Д.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-78.Docx

1526180984



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 453/АД150169

Улаанбаатар хот

САГ-2026/262/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлээгүй, 59 нэр төрлийн 263,901,210.00 /хоёр зуун жаран гурван сая есөн зуун нэг мянга хоёр зуун арван/ төгрөгийн өртөгтэй бараа ажил үйлчилгээг шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.", Засгийн газрын 2024 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол,"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Амаржаргал/, Захиргаа, удирдлагын газрын Санхүү албаны дарга /С.Майцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Д.ЭНХБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 458/А0150169

Улаанбаатар хот

САГ - 2026/262/НА - СТА - ТИЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь тайлант онд төлбөрийг хугацаанд төлж барагдуулаагүйгээс 106,846,461.43 /нэг зуун зургаан сая найман зуун дөчин зургаан мянга дөрвөн зуун харан нэгэн/ төгрөгийн өр төлбөр үүсгэн, үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 70 дугаар зүйлийн 70.5-т "Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах", гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7 "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Амаржаргал/, Захиргаа, удирдлагын газрын Санхүү албаны дарга /С.Майцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Д.ЭНХБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 455/АД150169

Улаанбаатар хот

САГ-2026/262/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд худалдан авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан 18 нэр төрлийн нийт 41,904,031.37 /дөчин нэгэн сая есөн зуун дөрвөн мянга гучин нэгэн/ төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна. Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр гаргах тохиолдолд цахим гарын үсэг хэрэглэж баталгаажуулна.", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын аравдугаар бүлгийн 10.6-д "Хөрөнгө хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж, үндсэн хөрөнгийн тодорхойлолтод нийцсэн бөгөөд байгууллагын хэрэгцээнд ашиглах, бусдад түрээслүүлэх зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1 "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй;"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй, хөрөнгийн ангиллыг буруу бүртгэсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Амаржаргал/, Захиргаа, удирдлагын газрын Санхүү албаны дарга /С.Майцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.ЦАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Д.ЭНХБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 454/А0150169

Улаанбаатар хот

САГ - 2026/262/НА - СТА - ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь 2025 оны 1-9 саруудад албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан орлон гүйцэтгэх үүрэгтэй нийт 16 ажилтанд ажил хавсран гүйцэтгэсний нийт 38,824,106.00 /гучин найман сая найман зуун хорин дөрвөн мянга нэг зуун зургаан төгрөгийн нэмэгдлийг хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох."; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин урамшуулал олгох журмын 2 дугаар зүйлийн 2.1-т "Төрийн албаны тухай хуулийн 42.1-т заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно." Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6-д "Ажилтанд эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсний болон бусад нэмэгдэл хөлсний хэмжээг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг олгохдоо холбогдох хууль, журмыг баримтлаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Амаржаргал/, Захиргаа, удирдлагын газрын Санхүү албаны дарга /С.Майцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Д.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тосгойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-78.Docx

1526180972



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 456/А0150169

Улаанбаатар хот

САГ-2026/262/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй нийт 50,188,154.00 /тавин сая нэг зуун наян найман мянга нэг зуун тавин дөрвөн/ төгрөгийн эм, эмийн хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүн, ахуйн материал нөөцөлж худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх," Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална." гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4 "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн", 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол;"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, баталсан төсвийг хэтрүүлэн худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Амаржаргал/, Захиргаа, удирдлагын газрын Санхүү албаны дарга /С.Майцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Д.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-78.Docx

1526180976



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 457 /АД150169

Улаанбаатар хот

САГ-2026/262/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь 2025 оны 6 дугаар сарын 4-ний өдөр "ГХГБ Ундрага" ХХК-тай байгуулсан ХБХСЗХТ/002/002 дугаартай худалдан авах гэрээний үнийн дүнгээс 2,000,000.00 /хоёр сая/ төгрөгийн хүнсний бүтээгдэхүүний илүү орлого авч өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал,"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хүнсний бүтээгдэхүүнийг бодит байдлаас илүү орлого авч, өр төлбөр үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Амаржаргал/, Захиргаа, удирдлагын газрын Санхүү албаны дарга /С.Майцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Д.ЭНХБААТАР